



ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2024 оны 06 дугаар сарын 06

Дугаар 16/03

Баян-Өндөр сум

Баяр наадмын зардлын задаргаа батлах,
зохицуулалт хийх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.15, 35.1.17 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1.а дахь заалт, 57 дугаар зүйлийн 57.2, 57.3 дахь хэсэг, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн “Зарим аймгийн баяр наадмын хугацааг тогтоох, хурдан морины бүсийн уралдааныг зохион байгуулах тухай” 233 дугаар тогтоолыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Монголын Тулгар Төрийн 2233, Их Монгол Улсын 818, Ардын хувьсгалын 103 жил-Үндэсний их баяр наадам, Эрдэнэт хот, Эрдэнэт үйлдвэрийг бүтээн босгосон “Илгээлтийн эзэд-50” жилийн ойн баяр, Хурдан морины 2024 оны Хангайн бүсийн уралдаан, Орхон аймгийн баяр наадмыг зохион байгуулах зардлын задаргааг нэгдүгээр, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн “Аймгийн 2024 оны төсөвт зохицуулалт хийх, 2023 оны төсвийн шилжих үлдэгдлийн жагсаалт батлах, өөрчлөлт оруулах тухай” 19/04 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралтад оруулах нэмэлт зардлын жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Дээрх үйл ажиллагаанд шаардагдах нийт 1,093,000,000 (нэг тэрбум ерэн гурван сая) төгрөгийн 610,000,000 (зургаан зуун арван сая) төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, 200,000,000 (хоёр зуун сая) төгрөгийг Илгээлтийн эздийн 50 жилийн ойн баяр, Хангай бүсийн хурдан морьдын уралдаан зохион байгуулахад уралдааны шагналд зарцуулах зардлаас, 218,000,000 (хоёр зуун арван найман сая) төгрөгийг Орхон аймаг, Эрдэнэт үйлдвэрийн хамтын ажиллагааны зардал, 65,000,000 (жаран таван сая) төгрөгийг шилжих үлдэгдлээс тус тус санхүүжүүлэхийг аймгийн Засаг дарга (М.Түмэнжаргал)-д зөвшөөрсүгэй.

3. Баяр наадмыг зохион байгуулах зардлын зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (М.Түмэнжаргал)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХБАТ

6179100063

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн Ээлжит бус XVI хуралдааны 16/03 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

МОНГОЛЫН ТУЛГАР ТӨРИЙН 2233, ИХ МОНГОЛ УЛСЫН 818, АРДЫН ХУВЬСГАЛЫН 103 ЖИЛ-ҮНДЭСНИЙ ИХ БАЯР, ИЛГЭЭЛТИЙН ЭЗДИЙН 50 ЖИЛИЙН ОЙ, ХАНГАЙН БҮСИЙН ХУРДАН МОРЬДЫН УРАЛДААН, ОРХОН АЙМГИЙН БАЯР НААДАМД БЭЛТГЭХ, ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Зохион байгуулагдах арга хэмжээ, зардлын нэр	Аймгийн батлагдсан төсөв	Зардлын задаргаа
1	Орон нутгийн хөгжлийн сангаас	818,000,000	
2	Худалдаа үйлчилгээний орлогоос	10,000,000	
3	Аймгийн 2023 оны төсвийн шилжих үлдэгдлээс	200,000,000	
Нэг: Ёслол хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгуулах зардал			
1	Хөдөлмөрийн баатар, төрийн соёрхолт, гавьяат зүтгэлтнүүдэд хүндэтгэл үзүүлэх		158,550,000
	Бүгд		158,550,000
Хоёр.Гадаад, дотоодын зочид төлөөлөгчдийг хариуцан ажиллах зардал			
1	Гадаад, дотоодын зочид төлөөлөгчдийг хүлээн авах, байрлуулах, хүндэтгэл үзүүлэх		34,450,000
	Бүгд		34,450,000
Гурав: Үндэсний бөхийн барилдааны зардал			
1	Үндэсний бөхийн барилдаан		61,300,000
	Бүгд		61,300,000
Дөрөв: Хурдан морины зардал			
1	Хурдан морьдын уралдаан		200,000,000
	Бүгд		200,000,000
Тав: Үндэсний сур, шагайн харвааны зардал			
1	Үндэсний сур, шагайн зардал		41,500,000
	Бүгд		41,500,000
Зургаа: Соёл урлаг, биеийн тамир, спортын зардал			
1	Наадмын нээлт, соёл урлаг, спортын арга хэмжээ		218,000,000
	Бүгд		218,000,000
Долоо.Хэвлэл мэдээлэл, сурталчилгаа хариуцсан зардал			
1	Хэвлэл мэдээлэл, сурталчилгаа болон телевизийн шууд дамжуулалт		70,000,000
	Бүгд		70,000,000
Найм: Худалдаа, тээвэр, үйлчилгээний зардал			
1	Худалдаа, тээвэр, үйлчилгээний зардал		10,000,000
2	Онцгой байдлын газрын морь барианы газарт ажиллах зардал		6,100,000
	Бүгд		16,100,000
Ес: Хот тохижилт, чимэглэлийн зардал			
1	Баяр наадам явуулах талбайн тохижилтын зардал		150,000,000
	Бүгд		150,000,000
Арав: Хэв журам хамгаалах зардал			
1	Хэв журам хамгаалах зардал		32,200,000
	Бүгд		32,200,000
Арван нэг: Наадмын төв комиссын зардал			
1	Наадмын төв комиссын зардал		5,000,000

2	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал		30,000,000
3	Лед дэлгэц, тайзны засвар		9,900,000
4	Монгол Улсын Төрийн далбааны өдөрт зориулсан цэргийн ёслолын жагсаал, Амарын хөшөөнд цэцэг өргөх арга хэмжээний зардал		3,000,000
5	Хурдан морины замын төлбөр /Булган аймгийн Бугат суманд/		8,000,000
	Бүгд		55,900,000
Баяр наадмын нийт зардал			
Нийт		1,028,000,000	1,028,000,000

-- 000 --

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн Ээлжит бус XVI хуралдааны 16/03 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

**АЙМГИЙН 2023 ОНЫ ТӨСВИЙН ШИЛЖИХ ҮЛДЭГДЛЭЭС
2024 ОНД САНХҮҮЖҮҮЛЭХ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ,
ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДЛЫН ЖАГСААЛТ**

Д/Д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эхлэх, дуусах хугацаа	Төсөвт өртөг	Аймгийн ИТХ-аар батлагдсан дүн
1	Засаг дарга		65,000,0	65,000,0
1.1	Төсөл, хөтөлбөр		65,000,0	65,000,0
1.1.1	Баяр наадмын нээлтийн арга хэмжээнд оролцох хүүхдүүдийн урамшуулал болон био ОО-ын зардал	2024	65,000,0	65,000,0

-- 000 --